



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 5/93

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, 9.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, 83.5 дахь хэсэг, яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.17 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 471 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стратеги төлөвлөлтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн Эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Лхагвасүрэнгийн Намхайноровын бичгээр гаргасан хүсэлтийг харгалзан албан тушаалаас нь 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.
2. Л.Намхайноровын ажлыг хүлээлцүүлэх комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, ажлыг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүлээлцэж, энэ хугацаанд ногдох цалин хөлс болон ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоог хийхийг яамны Ахлах нягтлан бодогч (Р.Содномцэрэн)-д үүрэг болгосугай.
3. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу хувийн хэргийг Л.Намхайноровт хүлээлгэн өгөхийг Төрийн захиргааны удирдлагын газарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Батбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.ОЧИРБАТ

142250541

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05
дугаар сарын 19-ны өдрийн 5/73 дугаар
тушаалын хавсралт

АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: П.Оюунцэцэг, Стратеги төлөвлөлтийн газрын дарга

Комиссын гишүүд: Ч.Амаржаргал, Стратеги төлөвлөлтийн газрын Эм,
эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтсийн Эмийн
чанарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах
шинжээч

Р.Содномцэрэн, Төрийн захиргааны удирдлагын
газрын Яамны ахлах нягтлан
бодогч;

Д.Амарбаясгалан, Төрийн захиргааны удирдлагын
газрын Ахлах архивч-операторч;

П.Энхболор, Төрийн захиргааны удирдлагын
газрын Яамны зохион байгуулагч, нярав